

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулан сургахад тулгамдаж буй асуудалд

О.Хулан, Х.Одончимэг

*Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсролын Суурь Судалгааны төв
МУБИС, докторант*

Хураангуй

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ердийн сургуульд элсэн суралцах эрх зүйн орчин Монгол улсад бүрдсэн гэж үзэж байгаа ч сургуульд хамрагдалт бага хувьтай байгаа шалтгааныг илрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 122 багшаас судалгаа авсан. Судалгаанаас үзэхэд 96.7 хувь нь ямар нэгэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сургалтад хамрагдаж байгаагүй бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 91.7 хувь нь сургалт авахыг хүсчээ. Хүүхэд бүрийн онцлогийг харгалзсан багшлах арга зүй, сургалтын орчин, хэрэглэгдхүүн, анги зохион байгуулалтын талаархи онол, практикийн ойлголтыг Ерөнхий Боловсролын Сургуулийн багш нарт түгээснээр багш нарын хандлага өөрчлөгдөж, хүүхэд нэг бүрийг амжилттай сургах боломжтой болно. Багш нар маань зөвхөн тусгай хэрэгцээт сурагчдын онцлогийг мэдээд зогсохгүй тэдний хэрэгцээг хангасан сургалтын арга зүйг үгүйлж байгаа нь судалгаанаас харагдлаа.

Түлхүүр үг

хүүхэд бүрийн онцлогийг харгалзсан багшлах арга зүй, анги зохион байгуулалт, тусгай хэрэгцээт боловсрол, багшийн хандлага, эрхзүйн орчин,

Удиртгал

Манай гариг дээр нэг тэрбум гаруй хүн хөгжлийн ямар нэг бэрхшээлтэй амьдарч байна. ДЭМБ-ын судалгаанаас үзвэл 15-аас дээш насны үйл ажиллагааны ноцтой алдагдалтай 110-190 сая (2,2-3,8 хувь) хүн байгаа аж. Түүнчлэн 15 хүртэлх насны 20 хүүхэд тутмын нэг нь буюу 93 сая орчим хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталсан Хүүхдийн Эрхийн Конвенцид Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд нь тусгай халамж болон ижил тэгш харьцааг хүлээн авах эрхтэй, боловсрол бол хүний үндсэн эрх, хүүхэд бүр өөрийн онцлогт тохирсон орчноор хангагдах эрхтэй хэмээн заасан.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай” НҮБ-ын конвенцид хөгжлийн бэрхшээлтэй хүний сурч боловсрох эрхийг хүлээн зөвшөөрч, алагчлалыг арилган тэгш боломж бүрдүүлэх тухай онцгойлон дурдаж, энэхүү зорилгод чиглэсэн тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох талаар тодорхой тэмдэглэсэн байна. 2012 онд БНСУ-ын Инcheon хотод зохион байгуулсан Ази, Номхон далайн бүс нутгийн төр засгийн тэргүүн нарын чуулга уулзалтаар манай бүс нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх 2013-2022 оны 10 жилийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Сайд нарын тунхаглал”-ыг гаргаж,

“Эрхийг бодит болгоё” хэмээх стратегийг тус тус баталсан. Тус стратегийн гол үзэл санаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүний бүх талын эрхийг хамгаалахад Ази, Номхон далайн бүс нутгийн улс орнуудын Засгийн газрын үүрэг амлалтыг бодитой болгоход чиглэсэн юм. Стратегийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрт оролцоо ба боловсролд хамруулалтыг өргөжүүлэх” хэмээх тавдугаар зорилгын хүрээнд нэгдүгээрт, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг төрсөн цагаас сургуульд орох хүртэлх хугацаанд аль болох эрт илрүүлж, хөгжлийн дэмжлэгийн үйлчилгээнд хамруулах; хоёрдугаарт, бага, дунд сургуульд хамрагдалтын тоог нэмэгдүүлэхийг тэргүүлэх зорилт болгожээ.

Бусад орнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сурах эрх зүйн орчин:

ХБНГУ-ын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусад хүмүүсийн нэгэн адил боловсрол эзэмших эрхтэй болохыг хуульчилж, төрөөс бүх иргэдэд заавал эзэмших үнэ төлбөргүй бүрэн дунд боловсролыг баталгаатай олгохыг заасан. (<https://behinderung.org/gesetze/schwbg.htm>)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагчдын хүсэл, сонирхлыг харгалзан

тусгай болон ердийн сургуульд сургадаг байна. Ихэнх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдийн нэгэн адил суралцдаг ба тусгай хэрэгцээтэй хүүхдүүд ердийн сургуульд сурах бүрэн боломжтой байдаг. Ердийн сургуулиуд эдгээр хүүхдүүдийн хэрэгцээнд тохируулан сурганы арга, арга зүйн үндсэн дээр зохих нөхцөлийг бүрдүүлсэн байна.

ОХУ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн хамгааллын тухай” хуулийн 19 дүгээр зүйлд “Төрөөс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсрол эзэмших явдлыг бүхий л талаар дэмжин, үүний тулд шаардлагатай нөхцөлийг баталгаатай хангана” (О социальной защите инвалидов в российской федерации”. www.docs.cntd.ru) гэж заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг бүх шатны боловсролыг үнэ төлбөргүй эзэмших эрхийг баталгаажуулсан бөгөөд энэ нь эдгээр иргэд бусад хүмүүсийн нэгэн адил хүний эрх, эрх чөлөөг эдлэх, тэдгээрийн бие хүний болон хувийн онцлог, боломжийг хөгжүүлэх, нийгмийн хөгжилд татан оролцуулахад чиглэгддэг байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших үйл явцад сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх дэмжлэг үзүүлэн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэрийн нөхцөлд сургахад нь дэмжлэг үзүүлнэ.

Хятад улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн боловсрол эзэмших эрхийг төрөөс баталгаажуулна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудад албан ёсны боловсрол олгоно... албан ёсны боловсрол эзэмшиж буй сурагчдад төрөөс сургалтын төлбөр ногдуулахгүй”(Law on the Protection of Persons with Disabilities. www.cdpf.org.cn/english/lawsdoc/)

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тусгай сургуулиуд байхын зэрэгцээ маш олон ердийн сургуулиуд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг элсүүлэн авч суралцуулдаг. Учир нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн асран хамгаалагчдын хүсэл, сонирхлыг харгалздаг байна.

Австрали улс Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг хуулиндаа 1. Боловсролын байгууллага хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хувьд дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хуулиар хориглоно:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүний суралцах хүсэлтийг хүлээн авахгүй байх, татгалзах,
- Суралцах нөхцөлөөр ялгавар тогтоох.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тоноглол хийхгүй байх, тоноглолыг

хязгаарлах, боловсролын байгууллагын зүгээс олгох аливаа хөнгөлөлтийг хязгаарлах,

- Суралцагчийг хасах
- Суралцагчид бусад хэлбэрийн хүндрэл учруулах.

2. Боловсролын байгууллага хүнийг хөгжлийн бэрхшээлтэй хувьд нь дараах хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хууль бус:

- Сургалтын хөтөлбөр болон дадлагын курсийн агуулгыг боловсруулахдаа суралцагчийн оролцох боломжийг хаасан, эсвэл хүндрэл учруулсан,
- Дээрх заалтад тусгагдсан агуулга бүхий сургалтын хөтөлбөр болон дадлагын курсийг батлах хэмээн тэгш хамруулан сургах нөхцөлийг тодорхой заажээ.

Олон улсад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах эрхзүйн орчинг ийнхүү тэгш хамруулан сургахаар тусгаж, хэрэгжүүлж ирсэн туршлагатай байдаг.

Монгол улсын хэмжээнд:

Монгол улсын Боловсролын тухай хуулийн Нэгдүгээр бүлгийн 5.1.3.Боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр, суралцагчийн хэрэгцээ, хувийн болон хөгжлийн онцлогт нийцсэн олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна; /Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

5.1.4.Иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана; /Энэ заалтад 2006 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/

6.3.Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй.

Хоёрдугаар бүлэг, 10.1 Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын Тогтоолд: (Улсын их хурлын тогтоол, 2017, х-15)

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

-Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, холбогдох байгууллага, албан тушаалтныг оролцуулан сургууль, цэцэрлэгийн хамран сургах тойрогт байгаа

хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог нарийвчлан гаргаж, тэгш хамруулан сургах орчныг бүрдүүлэн ажиллах;

-Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувидалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгжүүлж ажиллах;
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрмийн

1.6.1. Хүүхдийн хөгжлийн онцлог, өвөрмөц хэрэгцээ, нэр хүндийг хүндэтгэх;

1.6.2. үл ялгаварлах;

1.6.3. хүүхдийн эрхэд суурилах, тэгш оролцоог хангах гэж заажээ. Үүнээс үзэхэд Монгол улсад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд элсэн суралцах эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж байна. Монгол улсын хэмжээнд нийт 32000 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагаас зөвхөн 7279 хүүхэд сургуульд хамрагддаг байна. (Монгол улсын статистик судалгаа, 2017, х-12) Үлдсэн 23122 хүүхэд буюу нийт хүүхдийн 78 хувь нь гэртээ байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд сургуульд хамрагдалт бага хувьтай байгааг илрүүлэх зорилгоор СХД, БГД, ХУД, Налайх, БЗД, ЧД, СБД-ийн ерөнхий боловсролын сургуулийн 122 багшаас судалгаа авсан юм.

Танд тусгай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байсан туршлага байгаа юу?

Valid	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Тийм	37	30.3	30.3	30.3
Үгүй	85	69.7	69.7	100.0
Total	122	100.0	100.0	

Судалгаанд оролцогчдын 30.3 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байсан гэж хариулсан бол 69.7 хувь нь огт ажиллаж үзээгүй байна. Энэ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт бага байгаа гэдгийг батлах мэт.

ХБХ-тэй ажиллахад тулгарч байсан бэрхшээл? (нээлттэй асуулт)

Valid	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Онцлогт нь тохируулж заах аргазүй	13	10.7	10.7	10.7

Туслах багш нэмэлтээр ажиллуулах шаардлага тулгарсан.	2	1.6	1.6	12.3
Ойлголцоход хэцүү	9	7.4	7.4	19.7
Асаргаа сувилгаа	4	3.3	3.3	23.0
Олон нийт ТХХ-ийн талаар ойлголтгүй	2	1.6	1.6	24.6
Бусад хүүхдүүд ТХХ-ийг хэт өрөвдөж, дүү мэт харьцдаг.	2	1.6	1.6	26.2
Хичээл ойлгодоггүй	3	2.5	2.5	28.7
Эцэг эх, багшийн хамтын ажиллагаан дээр бэрхшээлтэй байсан.	2	1.6	1.6	30.3
Ажиллаж байгаагүй учраас мэдэхгүй байна.	85	69.7	69.7	100.0
Total	122	100.0	100.0	

69.7 хувь нь ХБХүүхдэд хичээл зааж үзээгүй учир мэдэхгүй гэсэн бол бусад ХБХүүхэдтэй ажиллаж байсан багш нарын 10.7 хувь нь “Онцлогт нь тохируулж заах аргазүй” тал дээр бэрхшээлтэй байсан гэж хариулжээ. Хичээл ойлгодоггүй, ойлголцоход хэцүү гэдэг бэрхшээлийг ч мөн адил заах аргазүй, багшийн сэтгэлзүйтэй холбож тайлбарлаж байна.



Эндээс үзэхэд багш нарын тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдийн талаарх эерэг бодолтойг, тэдэнд хичээл зааж чадна гэсэн итгэл үнэмшилтэй байгааг харуулсан. Бусад хөгжлийн бэрхшээлийн төрлөөр багш нарт таниулах сургалт хийх шаардлагатай байгааг илтгэж байна. 3 багш “Бүх хүүхдийг ялгалгүй хичээл заана”, 8 багш “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээл заамааргүй байна” гэж хариулсан байна.

ХБХ-ийг ЕБС-д сургахад багш нарт ямар бэрхшээл учирч байна вэ?

Valid	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Заах арга зүй	45	36.9	36.9	36.9
Туршлага байхгүй	5	4.1	4.1	41.0
Сургуулийн орчин, нөхцөл	14	11.5	11.5	52.5
Эцэг эхчүүдийн хандлага	6	4.9	4.9	57.4
Хичээлээр хоцрогддог	18	14.8	14.8	72.1
Ойлголцдоггүй	8	6.6	6.6	78.7
Тусгай хөтөлбөр хэрэгтэй	6	4.9	4.9	83.6
Мэдэхгүй байна.	17	13.9	13.9	97.5
Асаргаа	2	1.6	1.6	99.2
Бусад хүүхдүүдэд саад болдог	1	.8	.8	100.0
Total	122	100.0	100.0	

Энэ асуулт нь нээлттэй асуулт бөгөөд 36.9 хувь нь “Заах арга зүй”-н тал дээр бэрхшээлтэй байна гэж хариулсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид “Хичээлээр хоцрогддог” 14.8 хувь нь хариулсан бол 13.9 хувь нь “Мэдэхгүй байна” гэж хариулсан байна. Мөн туршлага байхгүй, сургуулийн орчин нөхцөл, эцэг эхчүүдийн хандлага, ойлголцдоггүй, тусгай хөтөлбөр хэрэгтэй, асаргааны асуудал, бусад хүүхдүүдэд саад болдог гэх хариултуудыг өгчээ. Та ХБХүүхдэд хичээл заахад бэлэн үү?

Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
40	32.8	32.8	32.8
63	51.6	51.6	84.4
19	15.6	15.6	100.0
122	100.0	100.0	

Нийт багш нарын 32.8 хувь нь Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хичээл заахаас тагталзахгүй байгаа нь сайн хэрэг боловч сурган хүмүүжүүлэх үүрэг хүлээсэн багш хүмүүсийн хувьд бол чамлалтай.

Та тусгай хэрэгцээт хүүхэдтэй ажиллах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдаж байсан уу?

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Тийм	4	3.3	3.3	3.3
Valid Үгүй	118	96.7	96.7	100.0
Total	122	100.0	100.0	

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ЕБС-д тэгш хамруулан сургахтай холбогдуулан сургалт авахыг хүсч байна уу?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Тийм	112	91.8	91.8	91.8
	Үгүй	10	8.2	8.2	100.0
	Total	122	100.0	100.0	

Эндээс үзэхэд 96.7 хувь нь ямар нэгэн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах сургалтад хамрагдаж байгаагүй бөгөөд нийт судалгаанд оролцогчдын 91.7 хувь нь сургалт авахыг хүсчээ. Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”-н талаар сургалт явуулах нэн шаардлагатай байгааг харуулж байна. Дараа дараагийн судлаач эрдэмтэд маань энэ асуудлыг гэгээн оюундаа тунгааж цааш судлах шаардлагатай байна.

Дүгнэлт

Монгол улсад Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг ердийн сургуульд тэгш хамруулан сургах эрхзүйн орчин бүрдсэн байна.

Ерөнхий боловсролын сургуульд багшилж байгаа багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн талаарх ойлголт дутмаг байна.

Ерөнхий боловсролын сургуульд багшилж байгаа багш нарын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах аргазүйг сайжруулах сургалт хэрэгтэй байна.

Ном зүй

Батцэнгэл Г.(2007), Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурган сэтгэлзүйн зарим асуудал, Улаанбаатар

Hyogo university of teacher education., Тусгай хэрэгцээт боловсрол, (2018), EDU press хэвлэх үйлдвэр

Ичинхорлоо Ш., .(2018) Боловсролын социологийн удиртгал, Улаанбаатар

Жадамба.Б., .(2000)“ “Анги танхимын зохион байгуулалт”, Улаанбаатар

Байгалмаа Ч.,(2013), “Багшийн мэргэжлийн хөгжил туршилт судалгаа”, Улаанбаатар

Батхуяг С., (2018), Судалгааны нэр томьёо, Улаанбаатар

Батхуяг С, Төртөгтох Б, Цогзолмаа Н., .(2017), Боловсрол судлалын судалгааны ажлын арга техник, Улаанбаатар

Боловсролын үнэлгээ олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, (2016),

EDU press хэвлэх үйлдвэр
Schwerbehindertengesetz (SchwbG). <https://behinderung.org/gesetze/schwbg.htm>
“О социальной защите инвалидов в российской

федераций”. www.docs.cntd.ru
Law on the Protection of Persons with Disabilities.
www.cdpf.org.cn/english/lawsdoc/

Challenging issues of children with special needs to attend school

Khulan.O, Odonchimeg.Kh
Mongolian National University of Education

Abstract

For the purpose of the paper, we surveyed secondary school teachers about their attitude including affective side of it, specifically open-ended questions about what their understanding to teach to children with special educational needs and to test the match between the teachers' attitude and legal framework. We have found that children with special educational needs have poor opportunity to experience the privilege to study at regular schools and teachers are required to have training of differentiated teaching methods. The legal environment is made up for the children with special educational needs to study in regular public schools in Mongolia but special education programs available to students today demand the appropriate environment at schools. Secondary school teachers are expected to help special needs students not only acquiring the necessary knowledge about them, but also in the methodology of differentiated instruction and classroom management.

Key words

Children with special educational needs, teachers' attitude, affective side of the attitude, legal framework.
